

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 10 дугаар сарын 08-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-5

1.Санал	3-5
----------------	------------

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Оюу толгой бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбоотой баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх/-ны 10 дугаар сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 05 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: С.Зулпхар;
Чөлөөтэй: П.Ганзориг, Б.Жаргалан;
Эмнэлгийн чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалтын газрын дарга Ч.Онончимэг, мөн газрын референт Д.Мөнхтуяа, ахлах мэргэжилтэн С.Сэргэлэн, Байнгын хороодын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Хянан шалгах түр хорооны дарга О.Батнайрамдал “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн удирдлагууд хуралдаанд оролцох боломжгүй гэсэн албан бичиг ирүүлсэн тул хуралдааныг ирэх долоо хоног хүртэл хойшлуулж байгаа талаар мэдэгдэж, хойшлуулав.

Хуралдаан 07 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 12 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

О.БАТНАЙРАМДАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХЯНАН
ШАЛГАХ ТҮР ХОРОО /ОЮУ ТОЛГОЙ БҮЛЭГ ОРДЫН АШИГЛАЛТАД МОНГОЛ
УЛСЫН ЭРХ АШГИЙГ ХАНГУУЛАХ, ХҮРТЭХ ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХТЭЙ
ХОЛБООТОЙ БАРИМТ БИЧИГ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ/
НЫ 10 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

О.Батнайрамдал: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Оюу толгой бүлэг ордын ашиглалтын асуудлаарх Хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул 2025 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд Оюу толгой компанийн танилцуулга мэдээллийг сонсох.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу толгой төслийн санхүүжилтийн хүүгийн зохистой байдлыг хянан үзэх өөрчлөх асуудлаарх хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийж санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн явц мэдээллийг сонсох.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 73 дугаар захирамжаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Оюу толгой бүлэг ордын талбайн хил зааг доторх ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Онтрэ компанийн хувьцааны төрийн эзэмшлийн хувь хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль Ашигт малтмалын тухай хуулийн тогтоомжид нийцүүлэн тогтоох талаар хөрөнгө оруулагч талтай хэлэлцээр хийж холбогдох бусад асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн явцыг мэдээллийг сонсох гэсэн асуудлууд орсон байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Хэлэлцэх асуудалдаа орцгооё. Эхний асуудал Оюу толгой компанийн танилцуулга мэдээллийг өнөөдөр сонсох ёстой байсан.

Улсын Их Хурлын энэ 7 хоногийн товд албан ёсоор Оюу толгой компанийн танилцуулга орсон боловч 10 сарын 7 гэдэг чинь өчигдөр юм байна. Өчигдөр Оюу толгой компаниас энэхүү хуралд оролцох боломжгүй ээ гэсэн албан тоотыг гүйцэтгэх захирлын гарын үсэгтэйгээр ирүүлсэн байна. Хянан шалгах түр хороо байгуулагдсанаасаа хойш яг өнөөдөр бол ингээд 3 сарын хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Оюу толгой компаниас ирсэн нууцын тамга дараагүй. Одоо бараг ганц албан тоот нь хуралд оролцох боломжгүй гэсэн ганц албан тоот л ирж байна л даа.

Оюу толгой хариуцлагатай ХК бол төрийн өмчийн оролцоотой буюу 34 хувь Монгол Улсын Засгийн газар эзэмшдэг. Монгол Улсад бүртгэлтэй Аж ахуйн нэгж байгаа. Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хувьд Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын төрийн 34 хувийн эзэмшил компанийн хувьд бол Хянан шалгах түр хороонд дуудагдсан байгаа.

Яг бусад компаниудтай бусад дуудаж байгаа аж ахуйн нэгжүүд болон төрийн байгууллагуудтай яг адилхан Парламентын 7 хоногийн товд албан ёсоор ороод бүх

байгууллагууд ирж байгаа. Гэхдээ өнөөдөр 3 сарын хугацаанд бол ганцхан ирэх боломжгүй гэсэн шалтгаантайгаар Оюу толгой компани ирсэнгүй.

Хянан шалгах түр хорооны яг энэ ажлын явцад бол Оюу толгой компаниас ойролцоогоор 30 гаруй мянган хуудас баримт материал нотлох баримт цуглуулах хүрээнд ирсэн. Гэхдээ 30 гаруй мянган хуудас баримт бүгд нууцын тамгатай. Тэр битгий хэл тэр 30 гаруй мянган хуудсаа явуулж байгаа албан тоотууд болгон нууцын тамгатайгаар ирж байсан.

Өнөөдөр ингээд хуралд оролцож чадахгүй гэсэн ганцхан албан тоот нь ирэхдээ нууцын тамгагүй ийм байдалтай л ирж байна 1 дүгээрт.

Хоёрдугаарт. Монгол Улсын парламент тэр дундаа парламент дээр байгаа Хянан шалгах түр хороонд дуудагдсан төрийн байгууллагууд Аж ахуйн нэгжүүд бүгдээрээ хүрч ирж өөрсдийн мэдээллээ хийх үүрэгтэй. Үүргийг өнөөдөр Оюу толгой албан бичиг явуулаад ирж амжихгүй ээ л гэсэн ийм л хариу ирж байна.

Тэгэхээр яг үнэнийг хэлэхэд энэ бол Монгол Улсын парламентад бас үл хүндэтгэлтэй хандаж байна гэж дүгнэж байна. 34 хувь нь Монгол Улсын төрийн эзэмшил компани байгаа. Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж. Тийм учраас Оюу толгой ХК-ийн гүйцэтгэх удирдлага болон Оюу толгойн ТУЗ-ийн дарга болон Монголын талын ТУЗ-ийн гишүүд заавал ирэх ёстой. Хянан шалгах Түр хороон дээр бидний дуудсан Засгийн газар нөгөө талаас хэлэлцээрт орох субъектүүдээс бид нар хэлэлцээрийн тактик болон хэлэлцээр дээр яригдах зүйлийг бид нар огт асуухгүй байгаа. Энэ бол Хянан шалгах хорооны чиг үүрэг ерөөсөө биш.

Энэ албан тоот дээрээ ч дурдсан байна л даа. Очоод хэлэлцээрт ярих юмаа яримааргүй байна. Бид нар хэлэлцээрийн юм асуухгүй ээ. Оюу толгой компани Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулаад анхны хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаас хойш 16 жил болж байгаа. Тэгэхээр Хянан шалгах түр хорооны чиг үүрэг бол Онтрэ компани дээр байгаа 2 лиценз эзэмшилтэй холбоотойгоор төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох, мөн Оюу толгойн баланс дээр байгаа хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүг бууруулах.

Энэ 2 чиглэлээр сүүлийн 16 жилийн туршид болсон үйл процесс гаргасан шийдвэрүүд дээр бид нар хяналт шалгалт хийж байгаа юм аа.

Тийм учраас өнөөдөр Оюу толгой компани энэ дээр Хянан шалгах түр хороон дээр заавал хүрч ирэх ёстой, мэдээллээр хангах ёстой. Энэ ч үүргийг бас хүлээх ёстой. Монгол Улсад бүртгэлтэй Монгол Улсын 34 хувийн эзэмшил төрийн өмчийн оролцоотой компани учраас энэ үүргээ бас бусад Аж ахуйн нэгжүүд шиг заавал хүлээх ёстой гэж үзэж байна.

Тийм учраас өнөөдрийн хуралдааныг Оюу толгой компанийн гүйцэтгэх удирдлага дараагийн хуралдаан дээр иртэл хойшлуулах саналыг гаргаж өнөөдрийн хуралдааныг хойшлуулж байна.

Дараагийн хуралдаанд парламентын тов дээр Оюу толгой компанийн танилцуулга, гүйцэтгэх удирдлага ирэх ёстой. Мөн Оюу толгой компанийн ТУЗ-ийн дарга болон Монголын талын ТУЗ-ийн гишүүдийг дараагийн хуралдаан дээр дараагийн Хянан шалгах түр хорооны 3 дахь өдрийн хуралдаан дээр ирэхээр товд

оруулаад өнөөдрийн хуралдааныг Оюу толгой компани ирээгүй учраас хойшлуулж байна аа. Өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА